



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/251

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Жаргалан багийн Лааганы 2 дугаар гудамжны 224 тоотод байрлах эрүүл мэндийн зориулалттай Жаргалан өрхийн эмнэлэг /2160633/-ийн эзэмшлийн 282 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Лхагважавын Эрдэнэцэцэг /ПЮ63110562/-д 15 жилийн хугацаагаар шилжүүлэн, үлдсэн 615 метр квадрат газрыг Жаргалан өрхийн эмнэлэг /2160633/-д хаягийг Лааганы 2 дугаар гудамжны 222 тоот болгон 15 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 Зах А/251 Ч